

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/210/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsege@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Билгүтэй Утас: 261628 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	18
3.5.3 Нэмэлт төсөв	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын



МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.НАРАНЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/321
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын Театрын музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монголын театрын музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,176.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Музейн захирлын 2020 оны А/16 дугаар тушаалаар үзмэрийн тасалбарын үнийг шинэчлэн баталсан ч тасалбараа шинэчлэн хэвлүүлээгүй, 2025 онд хэвлэмэл ангилал дугааргүй, үнэгүй хуучин тасалбарыг борлуулсан;
- Музейн өдрүүдээр ирсэн зочдод тараасан 237 ширхэг “Шилдэг үзмэрийн дээжис цомог”-ийг 2025 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлд бараа материалын үлдэгдлээр тайлагнаж, 8,176.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооллогыг бодитой хийгээгүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 12 дугаар зүйлийн 12.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.4.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд оролцож, "Ардын язгуур урлаг"-ийн өртөө байгуулах зардалд 12,917.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Соёлын сайдын 2023 оны А/317, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/253 дугаар тушаалыг тус тус үндэслэн Соёл урлагийн газраас 2025 оны 01/357 дугаар албан бичгээр улсын тооллого зохион байгуулах удирдамж ирүүлэн, тус музейн улсын тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр эхлүүлж, 72.93 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,923,184.00	53,657,796.00
34	УРЬДЧИЛГАА	10,350,000.00	3,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	10,350,000.00	3,500,000.00
35	Бараа материал	35,573,184.00	50,157,796.00
351	Түүхий эд материал	3,150,000.00	60,000.00
35110	Тусгай зориулалтын материал	3,150,000.00	60,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,153,580.00	6,817,500.00
354	Хангамжийн бараа материал	31,269,604.00	43,280,296.00
35410	Бичиг хэргийн материал	325,850.00	-
35420	Аж ахуйн материал	10,906,709.00	14,867,009.00
35470	Бусад хангамжийн материал	20,037,045.00	28,413,287.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	902,591,869.29	914,193,142.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	902,591,869.29	914,193,142.28
392	Биет хөрөнгө	894,113,449.63	907,803,142.22
39205	Машин тоног төхөөрөмж (компютер)	99,572,553.67	121,683,150.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,788,618.49)	(46,698,668.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,661,792.00	46,315,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,857,432.65)	(22,564,645.15)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	806,238,020.00	806,238,020.00
39213	Бусад үндсэн хөрөнгө	3,666,300.00	-
39213	Хуримтлагдсан элэгдэл	(1,208,549.90)	-
39217	Номын фонд	2,829,385.00	2,829,385.00
393	Биет бус хөрөнгө	8,478,419.66	6,390,000.06
39301	Програм хангамж	2,004,200.00	2,004,200.00
39302	Хуримтлагдсан хасагдуулга	(725,780.34)	(1,014,199.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
39303	Хуримтлагдсан хасагдуулга	(1,800,000.00)	(3,600,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	948,515,053.29	967,850,938.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	948,515,053.29	967,850,938.28
51	Засгийн газрын хувь оролцоо	948,515,053.29	967,850,938.28
51100	Засгийн газрын оруулсан капитал	70,433,859.73	70,433,859.73
51200	Хуримтлагдсан үр дүн	157,361,260.56	176,697,145.55
51210	Өмнөх үеийн үр дүн	119,470,635.00	157,361,260.56
51220	Тайлант үеийн үр дүн	37,890,625.56	19,335,884.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	720,719,933.00	720,719,933.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН 6=4+5	948,515,053.29	967,850,938.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	553,764,400.00	506,167,140.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,705,000.00	506,167,140.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,705,000.00	506,167,140.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	15,705,000.00	501,952,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	497,093,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,858,940.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	15,705,000.00	4,215,000.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	538,059,400.00	501,952,140.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	466,063,400.00	497,093,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжих	466,063,400.00	497,093,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,996,000.00	4,858,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,996,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	515,873,774.44	486,831,255.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,873,774.44	486,831,255.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,425,624.47	462,609,537.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,511,743.09	303,969,932.10
210101	Үндсэн цалин	156,239,704.13	162,654,338.44
210102	Нэмэгдэл цалин	52,418,018.96	63,144,814.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,788,170.00	39,770,903.62
210104	Урамшуулал	40,065,850.00	38,399,875.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,274,998.90	38,162,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,013,470.16	26,828,572.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,825,099.44	2,897,008.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,412,599.74	1,428,476.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,204,805.93	1,401,628.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,819,023.63	5,606,813.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,978,600.00	44,715,800.00
210304	Байрны түрээс	30,978,600.00	44,715,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,812,677.00	23,625,478.00
210401	Бичиг хэрэг	1,042,980.00	3,973,560.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	798,500.00	728,500.00

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	8,871,197.00	18,923,418.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	-
210604	Урсгал засвар	30,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,080,654.00	5,363,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,933,654.00	5,363,400.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	5,000,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	147,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,766,951.48	46,772,427.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,692,190.00	14,475,000.00
210901	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	343,300.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,731,461.48	32,297,427.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,448,149.97	24,221,717.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,303,300.00	19,055,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,778,300.00	19,055,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,525,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,144,849.97	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,109,843.97	-
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	35,006.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,166,517.90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,166,517.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,890,625.56	19,335,884.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	37,890,625.56	19,335,884.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	538,059,400.00	501,952,140.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,059,400.00	501,952,140.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	466,063,400.00	497,093,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,063,400.00	497,093,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,996,000.00	4,858,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	40,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,996,000.00	4,858,940.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	515,111,800.00	462,268,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,111,800.00	462,268,440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,663,650.03	438,046,722.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,185,357.13	303,969,932.10
210101	Үндсэн цалин	153,281,318.93	162,654,338.44
210102	Нэмэгдэл цалин	52,115,854.01	63,144,814.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,003,838.97	39,770,903.62
210104	Урамшуулал	40,784,345.22	38,399,875.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,396,998.90	38,162,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,013,470.16	26,828,572.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,825,099.44	2,897,008.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,412,599.74	1,428,476.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,204,805.93	1,401,628.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,941,023.63	5,606,813.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,978,600.00	44,715,800.00
210304	Байрны түрээс	30,978,600.00	44,715,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,282,400.00	4,009,790.00
210401	Бичиг хэргийн материал	1,251,000.00	265,990.00
210402	Тээвэр, шатахууны зардал	100,000.00	-
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	798,500.00	728,500.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	15,132,900.00	3,015,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,527,600.00	12,500,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	3,452,300.00	12,500,000.00
210604	Урсгал засвар	30,075,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,763,794.00	5,813,000.00

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,511,894.00	5,813,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	251,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал.	528,900.00	28,875,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал.	185,600.00	28,875,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	343,300.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,448,149.97	24,221,717.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,303,300.00	19,055,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,778,300.00	19,055,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,525,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,144,849.97	-
213303	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	2,109,843.97	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,006.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,166,517.90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,166,517.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,947,600.00	39,683,700.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (IV)	22,947,600.00	39,683,700.00
5	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,947,600.00	39,683,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,947,600.00	39,683,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,947,600.00)	(39,683,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	119,470,635.00	910,624,427.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	119,470,635.00	910,624,427.73
Тайлант үеийн үр дүн			37,890,625.56	37,890,625.56
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	157,361,260.56	948,515,053.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	157,361,260.56	948,515,053.29
Тайлант үеийн үр дүн			19,335,884.99	19,335,884.99
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	176,697,145.55	967,850,938.28

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	511,164,800.00	497,093,200.00	14,071,600.00	97.2
12	Татварын бус орлого	511,164,800.00	497,093,200.00	14,071,600.00	97.2
122	Тусламжийн орлого	511,164,800.00	497,093,200.00	14,071,600.00	97.2
122005	Улсын төсвөөс санхүүжих	511,164,800.00	497,093,200.00	14,071,600.00	97.2
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	511,164,800.00	457,101,922.10	54,062,877.90	89.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,164,800.00	457,101,922.10	54,062,877.90	89.4
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,109,600.00	438,046,722.10	54,062,877.90	89.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,777,200.00	303,969,932.10	1,807,267.90	99.4
210101	Үндсэн цалин	160,763,200.00	162,654,338.44	(1,891,138.44)	101.2
210102	Нэмэгдэл цалин	55,659,000.00	63,144,814.19	(7,485,814.19)	113.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,594,200.00	39,770,903.62	9,823,296.38	80.2
210104	Урамшуулал	39,760,800.00	38,399,875.85	1,360,924.15	96.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,162,500.00	38,162,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	26,584,200.00	26,828,572.90	(244,372.90)	100.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,894,600.00	2,897,008.65	(2,408.65)	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,447,300.00	1,428,476.20	18,823.80	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,447,300.00	1,401,628.45	45,671.55	96.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,789,100.00	5,606,813.80	182,286.20	96.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,715,800.00	44,715,800.00	-	100.0
210304	Байрны түрээс	44,715,800.00	44,715,800.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,739,800.00	4,009,790.00	(269,990.00)	107.2
210401	Бичиг хэрэг	1,195,400.00	265,990.00	929,410.00	22.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,346,000.00	728,500.00	617,500.00	54.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,198,400.00	3,015,300.00	(1,816,900.00)	251.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,813,800.00	12,500,000.00	38,313,800.00	24.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,813,800.00	12,500,000.00	38,313,800.00	24.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	10,790,100.00	5,813,000.00	4,977,100.00	53.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,813,000.00	5,813,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,110,400.00	28,875,700.00	9,234,700.00	75.8

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,110,400.00	28,875,700.00	9,234,700.00	75.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,055,200.00	19,055,200.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,055,200.00	19,055,200.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,055,200.00	19,055,200.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	39,991,277.90	(39,991,277.90)	100.0
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(39,991,277.90)	39,991,277.90	100.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(39,991,277.90)	39,991,277.90	100.0
6	Төсвийн бусад мэдээлэл				
61	Байгууллагын тоо	1	1		
62	Ажиллагсдын тоо	10	10		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7		100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,500,000.00
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00
2135	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,358,940.00
213505	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,358,940.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,858,940.00
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,858,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,858,940.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монголын театрын музейн эрхэм зорилго нь тайз дэлгэцийн урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалан хойч үедээ уламжлуулж, иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.

Монголын театрын музей нь Монгол улсын Театрын урлагийн үүсэл хөгжил, Монгол улс төдийгүй дэлхийн олон улс орны тайз дэлгэцийн ертөнцөд дүрээ мөнхөлж, нэр алдраа цуурайтуулсан олон арван урлаг, соёлын алтан үеийнхэн, залуу хойч үеийн уран бүтээлчдийн холбогдолтой түүхэн гэрэл зураг, уран зураг, гар бичмэл, тоглолтын хувцас, тайз, хувцасны эскиз, танилцуулга-хөтөлбөр, макет, үндэсний хөгжим, зурагт хуудас зэрэг эд өлгийн зүйлүүдийг дэлгэн үзүүлдгээрээ бусад төрлийн музейгээс онцлогтой байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монголын театрын музей нь Музейн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, Соёлын сайдын 2023 оны “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монголын театрын музейн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”

Монголын театрын музейн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дотоод аудитыг хийдэг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын театрын музей нь БСШУСС-ын 2017 оны А/40 тушаалаар баталсан сайдын хүрээний байгууллагад дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, хугацааг дагаж мөрддөг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,335.9 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал	10,350.0	3,500.0	(6,850.0)
Бараа материал	35,573.2	50,157.8	14,584.6
Үндсэн хөрөнгө	894,113.4	907,803.1	13,689.7
Биет бус хөрөнгө	8,478.4	6,390.0	(2,088.4)
Нийт хөрөнгө	948,515.0	967,850.9	19,335.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	70,433.8	70,433.8	-
Хуримтлагдсан үр дүн	157,361.3	176,697.1	19,335.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	720,719.9	720,719.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	948,515.0	967,850.9	19,335.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансдууд байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,850.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны гэрээний дагуу “Шилдэг үзмэрийн дээжис цомог”-ийг хэвлэлтээс хүлээн авч хөрөнгөөр бүртгэснээс 10,350.0 мянган төгрөгөөр буурч, тайлант онд “Кино болон киноны найруулгын тухай ном”-ыг хэвлүүлэх гэрээний урьдчилгаа төлбөр 3,500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 50,157.8 мянган төгрөг болж 14,584.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 37,677.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 23,092.4 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсанаас шалтгаалжээ;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 907,803.1 мянган төгрөг болж 13,689.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ССАЖЗЯ-наас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,120.0 мянган төгрөгийн компьютер, Захирлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/35 дугаар тушаалаар үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээр 39,683.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 62 дугаар тогтоолоор 17 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, 1,095.0 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн, нийт 43,898.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, шинэчлэн тогтоосон хөрөнгийн хуучин үнэ 29,800.3 мянган төгрөг, тайлант оны элэгдлийн зардал 408.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой;
- Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн тайлант оны үр дүн 19,335.9 мянган төгрөгөөр өссөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 618,439.1 мянган төгрөг, өөрийн орлогоор 14,000.0 мянган төгрөг, нийт 632,439.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардал 435.9 мянган төгрөг, байрны түрээс 119,036.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 47,500.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 8,096.4 мянган төгрөг, томилолт, зочны зардал 16,610.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,310.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 15,811.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалын зардал 3,550.0 мянган төгрөг, нийт 216,350.3 мянган төгрөгөөр бууруулж, 416,088.8 мянган төгрөгөөр баталсан байна.

ССАЖЗС-ын 2025 оны А/212 дугаар тушаалаар соёлын байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг 127,034.6 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн. Соёлын сайдын 2023 оны А/390 дугаар тушаалаар баталсан “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ын

дагуу байгууллагын хамт олны хурлаар хэлэлцэн багаж техник хэрэгсэл худалдан авахад 40,813.8 мянган төгрөг, урсгал засварт 10,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 38,110.4 мянган төгрөг, урамшуулалт цалинд 16,937.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 19,055.2 мянган төгрөг, байгууллагын үйл ажиллагаанд 2,117.3 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн. Олгосон санхүүжилтээс 30,286.0 мянган төгрөгийг буцаан татаж, байрны түрээсийн зардал 15,744.2 мянган төгрөг, нийт 46,030.2 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг 497,093.2 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 497,093.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 495,285.6 мянган төгрөгийг зарцуулж 1,807.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 495,285.6 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,807.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71706-Соёлын өв хөтөлбөр	497,093.2	495,285.6	1,807.6	99.6
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	372,110.3	370,302.7	1,807.6	99.5
1.2	80215-Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал	929.0	929.0	-	100.0
1.3	80219- Харуул хамгаалалтын зардал	2,634.0	2,634.0	-	100.0
1.4	81569- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	2,250.0	2,250.0	-	100.0
1.5	81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	119,169.9	119,169.9	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу тус музейн үйлчлэгчийн албан тушаалыг захирлын 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар цомхотгол хийж ажлаас чөлөөлсөн;
2. Музейн захирлын 2025 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 1,000 төгрөг, хоолны нэмэгдлийг 14,000 төгрөгөөр тооцож олгохоор баталж, олгосон;
3. Гадаад томилолт, арга хэмжээний зардал гараагүй;
4. Сургалт, семинар, хурал, зөвлөлгөөний зардал гараагүй;

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байхгүй, төлбөр тооцоо гараагүй;
6. Тайлант хугацаанд хамаарах төрд учирсан хохирол байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монголын театрын музей нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,858.9 мянган төгрөгийг нэмэлт орлогын дансанд төвлөрүүлж, хангамж, бараа материалд 1,500.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,358.9 мянган төгрөгийг дээд шатны төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	Шууд худалдан авалт	5	8,640.0	5	8,640.0	100.0	-	-
	Дүн	5	8,640.0	5	8,640.0	100.0	-	-

Харуул хамгаалалт, шуудан холбоо интернет, хангамжийн бараа материалын 5 төрлийн худалдан авалтын төлөвлөгөө баталж, шилэн дансанд байршуулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын театрын музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын дотооддоо баталж мөрддөг дүрэм, журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хооронд нь уялдаатай боловсруулан сайжруулах, Музейн үйл ажиллагааны онцлогыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн практик үйл ажиллагааны зааврыг өөрсдөө боловсруулан батлуулж мөрдөх талаар өгсөн нийцлийн асуудлын зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Ө.Ундармаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын театрын музей нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны нийт зардлын дүн 515,873.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,158.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монголын театрын музейн нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлсийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 болон 15 дугаар зүйлийн 15.1.1 - 15.1.8 дахь заалтуудад заасан хуулиар хориглох зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 181 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцроосон мэдээлэлгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 26 мөнгөн гүйлгээний мэдээллийг бүрэн байршуулжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Байгууллагын дотоод журмын хэрэгжилт:

Тус музейн үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн олгож байгааг шалгасан. Улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг 50.0 хүртэл хувиар тооцож олгосон нь Байгууллагын дотоод журамын 3.2.5-д "...үр дүнгийн урамшууллыг улирал тутам дүгнэн үндсэн цалингийн 25.0 хүртэл хувиар ...", тушаалын огноо дугааргүй баталсан "Музейн ажилтнуудын ажлыг үнэлэх, дүгнэх журам"-ын 5.3-д "Маш сайн ангилалд хамрагдсан төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшилд олгох мөнгөн урамшууллын 50.0 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгө тооцож олгоно" гэсэн 2 журмын заалтууд зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид нийцүүлэн музейн дотоодын дүрэм журмыг боловсруулан баталж, мөрдүүлэх зөвлөмж өгсөн.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт:

Тус музей нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын сайдын 2017 оны А/40 тушаалаар баталсан сайдын хүрээний байгууллагад дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, хугацааг дагаж мөрддөг. Өнгөрсөн хугацаанд харъяа салбарын бүтэц 2-3 удаа өөрчлөгдсөн, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийг тусгаагүй. Музейн онцлог бүртгэл, үзмэрийн тасалбар худалдан борлуулах болон зар сурталчилгаанд ашиглах танилцуулга боршур, үзмэрийн цомгийг бараа материалын дансанд бүртгэх ангилал, зардлын зориулалт, ангиллыг тодорхойлоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Музейн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн онцлогыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн практик үйл ажиллагааны зааврыг төсвөөс зардал гаргахгүй, өөрсдөө боловсруулан батлуулж, мөрдөх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан үр дүнгийн урамшуулалт цалин хөлсний хувь хэмжээ, нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 8,227.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 100.0 хувь байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	3	8,227.9	3	8,227.9	100.0
Нийт дүн		3	8,227.9	3	8,227.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсөв захирагч дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Байгууллагын дүрэм хэзээ, ямар албан тушаалтан, байгууллага баталсан нь тодорхойгүй байгаа тул Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ... хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх" гэсний дагуу байгууллагын дүрэм, дотоод журам, дүрмүүдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,377.5 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Музейн 2025 оны санхүүгийн тайланг СС-ын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй, Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн нэр буруу, 1А, 1Б, 1В, 2, 3, 4-р тодруулгыг дутуу тайлагнасан, Байгууллагын гүйцэтгэлийн тайланд үр дүнг хувиар илэрхийлж, төсөв гүйцэтгэлийн дүнгээр зэрэгцүүлээгүй нь УСНББОУС 1.21 "Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын, үр дүнгийн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан ба батлагдсан төсвийг олон нийтэд тайлагнахдаа төсөв болон гүйцэтгэлийн дүнгийн харьцуулалтыг тусад нь нэмэлт тайлангаар эсвэл санхүүгийн тайлан дээр нэмэлт баганаар харуулах, НББ-ийн бодлого ба санхүүгийн тайлангийн тэмдэглэл", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7-д "төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх" гэсэнтэй нийцээгүй, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй;
2. Үзмэрийн тасалбар 2,059 ш 60.0 мянган төгрөгийг Бичиг хэргийн материал дансанд, Шилдэг үзмэрийн дээжис 63 ш 2,173.5 мянган төгрөг, Бөмбөгөр ногоон театр зурагт альбом 129 ш 4,644.0 мянган төгрөгийг Бусад хангамжийн материал дансанд, нийт 6,877.5 мянган төгрөгийг ангилал буруу бүртгэсэн нь УССНББОУС 12.9.6 "бараа материалд дараах зүйлс орно... үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4-т "үнэн зөв байх" гэсэнтэй нийцээгүй, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй;
3. Тайлант онд "Кино болон кино найруулгын тухай ярианууд ном хэвлүүлэх" 8,500.0 мянган төгрөгийн гэрээ хийж, хэрэгжилтийг дүгнээгүй, гэрээний төлбөр 3,500.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний хураамж болон бусад бараа үйлчилгээний зардлуудад хуваан бүртгэсэн нь УСНББОУС 29.45 "Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлээгүй тохиолдолд, анх удаа хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага хөрөнгө ба өр төлбөрийг гаргахад эсвэл худалдан авахад шууд хамаарах ажил гүйлгээний зардлыг нэмсэн бодит үнэ цэнээр хэмжих ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 8,176.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 8,176.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчил 8,176.5 мянган төгрөг нь бидний тогтоосон 5,158.7 мянган төгрөгийн материаллаг байдлаас давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1. Албан шаардлага:

1. Музейн захирлын 2020.06.22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар үзмэрийн тасалбарын үнийг шинэчлэн баталсан ч тасалбараа шинэчлэн хэвлүүлээгүй, 2025 онд хэвлэмэл дугааргүй, ангилал, үнэгүй хуучин тасалбарыг борлуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;" гэж заасантай нийцээгүй, батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шаардлага хангасан үзмэрийн тасалбарыг хэвлүүлж, ашиглах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Шалгагдагч байгууллага нь музейн өдрүүдээр ирсэн зочидод тараасан 237 ширхэг 8,176.5 мянган төгрөгийн Шилдэг үзмэрийн дээжис цомгийг 2025 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлд бараа материалын үлдэгдлээр тайлагнаж, хөрөнгийн тооллогыг бодитой хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4.1-т "Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэсэн заалттай тус тус нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай гүйцэтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлт болон Нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 2 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн нэр буруу, 1А, 1В, 1В, 2, 3, 4-р тодруулга дутуу тайлагнасан	1	-	1	-			1	-				
2	Үзмэрийн тасалбар 2,059 ш 60.0 мянган төгрөгийг Бичиг хэргийн материал дансанд, Шилдэг үзмэрийн дээжис 63 ш 2,173.5 мянган төгрөг, Бөмбөгөр ногоон театр зурагт альбом 129 ш 4,644.0 мянган төгрөгийг Бусад хангамжийн материал дансанд, нийт 6,877.5 мянган төгрөгийг ангилал буруу бүртгэсэн	1	6,877.5			1	6,877.5	1	6,877.5				
3	"Кино болон кино найруулгын тухай ярианууд ном хэвлүүлэх" 8,500.0 мянган төгрөгийн гэрээ хийж, хэрэгжилтийг дүгнээгүй, гэрээний төлбөр 3,500.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн.	1	3,500.0			1	3,500.0	1	3,500.0				
Дүн		3	10,377.5	1	-	2	10,377.5	3	10,377.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Музейн захирлын 2020.06.22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар үзмэрийн тасалбарын үнийг шинэчлэн баталсан ч тасалбараа шинэчлэн хэвлүүлээгүй, 2025 онд хэвлэмэл дугааргүй, ангилал, үнэгүй хуучин тасалбарыг борлуулсан байна.	1	-			1	-						
2	Шалгагдагч байгууллага нь музейн өдрүүдээр ирсэн зочидод тараасан 237 ширхэг 8,176.5 мянган төгрөгийн Шилдэг үзмэрийн дээжис цомгийг 2025 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлд бараа материалын үлдэгдлээр тайлагнаж, хөрөнгийн тооллогыг бодитой хийгээгүй байна.	1	8,176.5			1	8,176.5						
Дүн		2	8,176.5	-	-	2	8,176.5	-	-	-	-	-	-

Монголын театрын музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	Улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг 50.0 хүртэл хувиар тооцож олгосон нь Байгууллагын дотоод журамын 3.2.5-д "...үр дүнгийн урамшууллыг улирал тутам дүгнэн үндсэн цалингийн 25 хүртэл хувиар ...", огноо дугааргүй баталсан "Музейн ажилтнуудын ажлыг үнэлэх, дүгнэх журам"-ын 5.3-д "Маш сайн ангилалд хамрагдсан төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшилд олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгө тооцож олгоно" гэсэн 2 журамын зөрүүтэй заалтыг баримталсан байна.	1	-						1	-
2	Тус байгууллага нь БСШУСС-ын 2017 оны А/40 тушаалаар баталсан сайдын хүрээний байгууллагад дагаж мөрдөх НБББББ, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, хугацааг дагаж мөрддөг.Өнгөрсөн хугацаанд харъяа салбарын бүтэц 2-3 удаа өөрчлөгдсөн, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийг тусгаагүй. Музейн онцлог бүртгэл үзмэрийн тасалбар, худалдан борлуулах болон зар сурталчилгаанд ашиглах танилцуулга боршур, үзмэрийн цомгийг бараа материалын дансанд бүртгэх ангилал, зардлын зориулалт, ангиллыг тодорхойлоогүй байна.	1	-						1	-
Дүн		2	-						2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 244/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/210/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын Театрын музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Музейн захирлын 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар үзмэрийн тасалбарын үнийг шинэчлэн баталсан ч тасалбараа шинэчлэн хэвлүүлээгүй, 2025 онд хэвлэмэл дугааргүй, ангилал, үнэгүй хуучин тасалбарыг борлуулсан байна.

Энэ нь Соёлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийн хэмжээг үүсгэн байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр тогтооно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтална" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй байх" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Музейн үзмэрийн тасалбарыг тогтоосон үнэ тариф, тасалбарын ангилал, хэвлэмэл дугаартай болгон хэвлүүлж, үйлчилгээнд ашиглаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын театрын музейн Захирал /Д.Наранжаргал/, Нягтлан бодогч /Н.Эрдэнэбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 245/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/210/НА - СТА - ТИЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын Театрын музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллага нь музейн өдрүүдээр ирсэн зочдод тараасан 237 ширхэг 8,176,500.00 /найман сая нэг зуун далан зургаан мянга таван зуун/ төгрөгийн Шилдэг үзмэрийн дээжис цомгийг 2025 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлд бараа материалын үлдэгдлээр тайлагнаж, хөрөнгийн тооллогыг бодитой хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4.1-т "Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2 "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын театрын музейн Захирал /Д.Наранжаргал/, Нягтлан бодогч /Н.Эрдэнэбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА